



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/39

Мандалговь

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комиссыг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн хэмжээнд шинээр баригдсан (бага, дунд, өндөр төвөгшилтэй) барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, онцгой төвөгшилтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар, их засвар, шинэчлэлт хийгдсэн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

Хоёр. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг холбогдох хууль, тогтоомж, дүрмийн дагуу чанартай зохион байгуулахыг комиссын дарга аймгийн Засаг даргын орлогч (Ж.Мөнхчулуун), аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж) нарт үүрэг болгосугай.

Гурав. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн)-д даалгасугай.




ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

488010092


Аймгийн Засаг даргын 2019 оны
01 дүгээр сарын 23 ны өдрийн 1/39
дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



**БАГА, ДУНД, ӨНДӨР ТӨВӨГШИЛТЭЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

- Комиссын дарга: -Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга;
- Нарийн бичгийн дарга: -Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн;
- Гишүүд:
- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын төлөөлөл;
 - Барилгын хөгжлийн төвийн төлөөлөл (шаардлагатай тохиолдолд)
 - Зураг төслийн байгууллагын төлөөлөл (холбогдох зураг төсөл зохиогчид);
 - Аймгийн Онцгой байдлын газрын төлөөлөл (холбогдох улсын байцаагчид);
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл;
 - Захиалагчийн төлөөлөл;
 - Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;
 - Инженерийн хангамжийн байгууллагын төлөөлөл;
 - Ашиглалт хариуцах байгууллагын төлөөлөл;
 - Аймгийн Архивын тасгийн төлөөлөл;


Аймгийн Засаг даргын 2019 оны
01 дүгээр сарын 2-ны өдрийн /44/
дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**ОНЦГОЙ ТӨВӨГШИЛТЭЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

- Комиссын дарга: -Аймгийн Засаг даргын орлогч;
- Нарийн бичгийн дарга: -Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга
- Гишүүд:
- Холбогдох төрийн төв байгууллагын төлөөлөл;
 - Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын төлөөлөл (холбогдох улсын байцаагчид);
 - Барилгын хөгжлийн төвийн төлөөлөл
 - Зураг төслийн байгууллагын төлөөлөл (холбогдох зураг төсөл зохиогчид);
 - Аймгийн Онцгой байдлын газрын төлөөлөл (холбогдох улсын байцаагчид);
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл;
 - Захиалагчийн төлөөлөл;
 - Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;
 - Инженерийн хангамжийн байгууллагын төлөөлөл;
 - Ашиглалт хариуцах байгууллагын төлөөлөл;
 - Аймгийн Архивын тасгийн төлөөлөл;

Аймгийн Засаг даргын 2019 оны
01 дүгээр сарын 23-ны өдрийн 1/39
дугаар захирамжийн 3 дугаар хавсралт



**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ИХ ЗАСВАР,
ШИНЭЧЛЭЛТИЙН АЖЛЫГАШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

- Комиссын дарга: -Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга
- Нарийн бичгийн дарга: -Захиалагчийн төлөөлөл
- Гишүүд:
- Зураг төслийн байгууллагын төлөөлөл (холбогдох зураг төсөл зохиогчид)
 - Аймгийн Онцгой байдлын газрын төлөөлөл (тохиролцсоноор)
 - Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл
 - Ашиглалт хариуцах байгууллагын төлөөлөл
 - Аймгийн Архивын тасгийн төлөөлөл